

**Иргэн, захиргааны хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх
ажиллагаа**

**ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ГАРЧ БУЙ ӨРГӨДӨЛ,
ГОМДЛЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ**

**APPLICATIONS, CAUSES AND CONDITIONS OF COMPLAINT
EMERGING IN EXECUTIVE ACTION GETTING**



Ц.Номин

*Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
магистрант, ахлах дэслэгч*

Хураангуй: Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гарч буй өргөдөл, гомдолд хийсэн судалгаанд үндэслэн өргөдөл, гомдол гарах шалтгаан, нөхцөл, үр дагаврыг тодорхойлж, түүнийг бууруулах санал боловсруулахыг зорилоо.

Abstract: Based on applications and complaints studies, the decision aims to identify the causes, conditions and consequences of the complaint and to develop proposals to reduce it.

Түлхүүр үгс: шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, өргөдөл, гомдол, шийдвэр гүйцэтгэгч, төлбөр төлөгч, гуравдагч этгээд

Keywords: executive action, petition, complaint, decision executive, payer, third party recipient

Удиртгал

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хуулийн дагуу, шуурхай биелүүлж, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээдийн эрхийг сэргээн, хамгаалах зорилготой билээ.

Шүүхийн шийдвэрийг шуурхай биелүүлэхэд хууль эрх зүйн оновчтой зохицуулалт чухал үүрэг, ач холбогдолтой, практикаас харахад эрх зүйн зохицуулалтын эерэг ба сул тал нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шууд нөлөөлж, нэг бол үр дүнгээ өгч, нэг бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үр дүнгүй болгож

байдаг тул хуулийн зүйл заалтыг нэг мөр ойлгох, практикт зөв хэрэглэх асуудал чухал байдаг.¹

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гарч буй өргөдөл, гомдол нь жилээс жилд өсч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт гарч буй өргөдөл, гомдлын 70 хувийг зөвхөн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай болон шийдвэр гүйцэтгэгчтэй холбогдуулан гаргасан гомдол эзэлж байгаа нь анхаарал хандуулах асуудал болсны илрэл билээ.

Энэ асуудал нь зөвхөн төв байгууллагад гарах өргөдөл, гомдлын дийлэнх хэсгийг эзлэхээс гадна, ажлын ачаалал үүсгэх, шүүхийн шийдвэр биелүүлэхэд хүндрэл үүсгэх, удаашруулах сөрөг үр дагавартай байдаг.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлд “Төрийн байгууллагууд өргөдөл, гомдлын агуулгад судалгаа дүгнэлт хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гарч буй өргөдөл, гомдолд судалгаа хийж, гомдол гарах болсон шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг багасгах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замыг эрэлхийлж энэхүү сэдвийг сонгосон болно.

Үндсэн хэсэг

Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын үндэслэл болон үр дагаврын шинжээр нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Арбитрын тухай хуулиар шийдвэрлэдэг бөгөөд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд холбогдуулан гаргасан өргөдөл, гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд зааснаар шийдвэрлэдэг.

Иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт болон бусад асуудлаар төрийн байгууллага албан тушаалтанд хандан гаргасан хүсэлтийг **өргөдөл** гэнэ. Өргөдөл нь санал мэдэгдэл, гомдлын шинжтэй байж болно. Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан хүсэлтийг **санал** гэнэ. Үндсэн хууль, бусад хууль тогтоомжил заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан хүсэлтийг **мэдэгдэл** гэнэ. Өөрөөр хэлбэл иргэд хамтарч мэдэгдэл гаргадаг. Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг

¹ Бямбарагчаа, С. Үл хөдлөх хөрөнгийн албадан дуудлага худалдааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. Магистрын зэрэг горилсон судалгааны ажил. Уб., 2022.

гомдол гэнэ. Гомдлыг тухайн байгууллагын удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан байна. **Өргөдөл гомдлыг шийдвэрлэх**¹ гэж өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг бүх талаас нь судлан үзэж, түүний дагуу хууль тогтоомжид нийцүү лэн холбогдох арга хэмжээ авсныг мэдэгдэж, хуулийн хугацаанд багтаан хариу өгөхийг хэлнэ.

Монгол Улсын иргэн, Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн дангаар болон хамтарч төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй. Өргөдөл, гомдлыг төрийн албан ёсны хэл бичгээр, амаар, цахим хэлбэрээр дамжуулан гаргана².

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хуулийн дагуу, шуурхай биелүүлж, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн төлбөр авагч иргэн, хуулийн этгээдийн эрхийг сэргээн, хамгаалах зорилготой бөгөөд төлбөр төлөгчийн хөрөнгөнд шүүхийн шийдвэрийн үндсэн дээр хуулийн дагуу төрийн албадлага хэрэглэн халдах, төлбөр төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах, албадан худалдан борлуулах замаар хэрэгжүүлдэг онцлогтой.

Шийдвэр гүйцэтгэх ажилагаанд болон албан тушаалтанд холбогдуулан гаргасан гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг баримтлан шийдвэрлэх бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан арга хэмжээ, түүний гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн арга хэмжээг гүйцэтгэсэн өдрөөс хойш, энэ тухай мэдээгүй бол олж мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж болно. Ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэж, тогтоол гаргана. Тогтоолыг зөвшөөрөөгүй тохиолдолд хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно³” гэж заасан байна. Тэгвэл тус хуулинд дараах асуудлаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гомдол гаргах эрхгүй байхаар зохицуулжээ. Үүнд:

- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд хөрөнгийг албадан худалдан борлуулах шийдвэрийн талаар болон хөрөнгийн үнэлгээний талаар энэ хуулийн 55.7-д заасны дагуу шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлсэн бол тухайн

¹ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль. 1995.

² Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль. 1995.

³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017.

асуудлаар хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагааны явцад шүүхэд дахин гомдол гаргах эрхгүй

- Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоолын талаар шүүхэд гомдол гаргахгүй

- Энэ хуульд өөрөөр заагаагүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр, үйл ажиллагаанд энэ хуульд заасан гомдол гаргах хугацааг хэтрүүлсэн тохиолдолд гаргасан гомдлыг гомдол гаргагчид буцааж, гомдол гаргаагүйд тооцно

- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхээс бусад тохиолдолд энэ хуулийн 29.1.1, 29.1.2, 29.1.3, 29.1.4, 29.1.8-д заасны дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэрт гомдол гаргах эрхгүй

- Төлөөлөгчийн гаргасан гомдлыг шүүх хянан шийдвэрлэсэн бол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд тухайн асуудлаар дахин гомдол гаргах эрхгүй

- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд хөрөнгийг албадан худалдан борлуулах шийдвэрийн талаар болон хөрөнгийн үнэлгээний талаар энэ хуулийн 55.7-д заасны дагуу шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлсэн бол тухайн асуудлаар хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагааны явцад шүүхэд дахин гомдол гаргах эрхгүй байхаар тус тус зохицуулжээ¹.

Шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар:

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 36321 гүйцэтгэх баримт бичгийн 1.8 их наяд төгрөгийг биелүүлэхээс 19693 гүйцэтгэх баримт бичгийн 339.0 тэрбум төгрөгийг биелүүлж, 16628 гүйцэтгэх баримт бичгийн 1.4 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй, гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийн улсын дундаж үзүүлэлт 54.2 хувь, мөнгөн дүн 18.9 хувьтай ажилласан ба өмнөх оны мөн үеэс гүйцэтгэх баримт бичгийн статистик үзүүлэлт 2.5 хувиар өссөн, мөнгөн дүн 3.6 хувиар буурсан үзүүлэлттэй ажиллалаа.

2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 44731 гүйцэтгэх баримт бичгийн 2.6 их наяд төгрөгийг биелүүлэхээс 24406 гүйцэтгэх баримт бичгийн 788.3 тэрбум төгрөгийг биелүүлж, 20325 гүйцэтгэх баримт бичгийн 1.8 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй, гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийн улсын дундаж үзүүлэлт 54.6 хувь, мөнгөн дүн 29.8 хувьтай ажилласан.

2023 оны 9 дүгээр сарын байдлаар нийт биелүүлбэл зохих 46.533 гүйцэтгэх баримт бичгийн 2.562.053.841.6 төгрөгөөс 21043 гүйцэтгэх баримт бичгийн

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017.

438.038.412.0 төгрөгийг бүрэн биелүүлж, 25490 гүйцэтгэх баримт бичгийн 2.124.015.429.6 төгрөгийн үлдэгдэлтэй гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 45.2 хувь, мөнгөн дүнгийн бодит биелэлт 17.1 хувийн биелэлттэй ажилласан байна.

Хүүхдийн тэтгэлгийн гүйцэтгэх баримт бичигт 2021 онд биелүүлбэл зохих 12724 гүйцэтгэх баримт бичгийн 70.4 тэрбум төгрөгөөс 1444 гүйцэтгэх баримт бичгийн 36.4 тэрбум төгрөгийг бодитой биелүүлснээс 30.3 тэрбум төгрөгийг хэсэгчлэн төлүүлжээ. Гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 11.3 хувийн үзүүлэлттэй, 11280 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар хүүхдийн тэтгэлгийн биелүүлбэл зохих 13526 гүйцэтгэх баримт бичгийн 47.8 тэрбум төгрөгөөс 1272 гүйцэтгэх баримт бичгийн 20.1 тэрбум төгрөгийг бодитой биелүүлснээс 14.9 тэрбум төгрөгийг хэсэгчлэн төлүүлж, гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 9.4 хувийн үзүүлэлттэй, 12254 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байна.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар 13989 гүйцэтгэх баримт бичгийн 45.8 тэрбум төгрөгөөс 872 гүйцэтгэх баримт бичгийн 17.0 тэрбум төгрөгийг бодитой биелүүлж, гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 6.2 хувийн үзүүлэлттэй, 13117 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байна.

Тухайлбал Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Улсын хэмжээнд биелүүлбэл зохих гүйцэтгэх баримт бичгийн 60 гаруй хувьд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 2023 оны 9 дүгээр сарын статистик мэдээгээр тус газар нь биелүүлбэл зохих 22759 гүйцэтгэх баримт бичгийн 1.917.748.010.3 төгрөгөөс 9137 гүйцэтгэх баримт бичгийн 358.645.802.7 төгрөгийг бүрэн биелүүлэн дуусгавар болгож, 13.622 гүйцэтгэх баримт бичгийн 1.559.097.201.6 төгрөгийн үлдэгдэлтэй бодит биелэлт 40,1 хувьтай ажилласан нь тухайн харилцаанд оролцогчдын хөндөгдсөн эрхийг сэргээх үйл ажиллагаа удаашралтай, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх нөхцөл хангагдахгүй байгааг харуулж байна. Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байх нь өргөдөл, гомдол гарах хамгийн гол шалтгаан болох бөгөөд шүүхийн шийдвэр биелүүлэхэд тулгамдаж буй асуудал нь гарч буй өргөдөл, гомдолтой салшгүй холбоотой.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шүүхийн шийдвэр биелэгдэхгүй, төлбөр төлөгдөхгүй байгаа шалтгааныг ангилж харуулбал:

Төлбөрийн чадваргүй буюу төлбөрт албадан гаргуулах эд хөрөнгөгүйгээс ажиллагаа удааширсан 7264 гүйцэтгэх баримт бичгийн 605.344.397.4 төгрөгийн буюу 28,5 хувь

Оршин суух хаяг тодорхойгүй болон эрэн сурвалжлах ажиллагаа явагдаж байгаа 1784 гүйцэтгэх баримт бичгийн 148.681.080.0 төгрөгийн буюу 7 хувь

Хорих ял эдэлж байгаа 651 гүйцэтгэх баримт бичгийн 44.569.861.5 төгрөгийн буюу 2.8 хувь

Төлбөрийг хэсэгчлэн төлдөг 3962 гүйцэтгэх баримт бичгийн 491.950.918.2 төгрөгийн буюу 17.2 хувь

Бусад шалтгаанаар төлбөр төлөгдөөгүй 11829 гүйцэтгэх баримт бичгийн 833.469.172.3 төгрөгийн буюу 44.5 хувь байна¹.



Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А217, А167, А303 дугаар тушаалаар тус албаны харьяа чиг үүрэг хэрэгжүүлж буй газар, хэлтсийг 3 бүсэд хувааж, бүсээс хамаарч нэг шийдвэр гүйцэтгэгчид 120-180 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах жишиг нормативыг тогтоосон боловч сүүлийн 3 жилийн дундаж үзүүлэлт болох 51324 гүйцэтгэх баримт бичгийг 244 шийдвэр гүйцэтгэгчийн тоотой харьцуулахад нэг шийдвэр гүйцэтгэгчид 210 гүйцэтгэх баримт бичиг оногдож, тогтоосон жишиг нормативаас 30-102 гүйцэтгэх баримт бичгээр илүү ачаалалтай ажиллаж байгаа нь шүүхийн шийдвэрийн биелэлтэд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

---o0o---

¹ Зая.С. Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байгаа шалтгаан, нөхцөл өгүүлэл. Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам хэлэлзүүлэг. 2023